СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

2025 XII

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

www.sukhbaatar.nso.mn

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН САРЫН ТАНИЛЦУУЛГА

2025
12 сар

Баруун-Урт сум

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-X ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		

a^x x нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- мянга =1000
- сая $=10^6$
- тэрбум $=10^9$
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- мян. мянга
- % хувь
- кВт.ц киловатт цаг
- ккал килокалори
- $м^2$ метр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- ш ширхэг

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

	Ерөнхий тэмдэглэл	2
	Үндсэн үзүүлэлтүүд	4
I	Хүн ам	6
II	Хөдөлмөр	9
III	Нийгмийн даатгал, халамж	11
IV	Боловсрол	13
V	Эрүүл мэнд	16
VI	Соёл, урлаг	18
VII	Гэмт хэрэг	19
VIII	Мөнгө, банк	20
IX	Арилжааны даатгал	21
X	Орон нутгийн төсөв	22
XI	Төсөл, хөтөлбөр	23
XII	Үнэ	24
XIII	Статистикийн бизнес регистрийн сан	28
XIV	Мал аж ахуй	30
XV	Газар тариалан	36
XVI	Аж үйлдвэр	38
XVII	Тээвэр	42
	Хавсралт хүснэгтийн жагсаалт	44
	Хавсралт хүснэгтүүд	46

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 12 дугаар сарын байдлаар

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Өөрчлөлт	
		2023	2024	2025	Дүн	Хувь
ХҮН АМ, ӨРХ						
Өрхийн тоо	тоо	19 481	19 700	19 712	12	0.1
Хүн амын тоо	хүн	65 995	66 209	66 535	326	0.5
Төрсөн хүүхэд /Улсын бүртгэлийн мэдээ/	хүн	1 337	1 227	905	- 322	-26.2
ХӨДӨЛМӨР						
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	302	234	277	43	18.4
НИЙГМИЙН ХАЛАМЖ						
Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон дүн	сая.төг	13 019.8	16 461.7	18 726.1	2 264.4	13.8
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид	хүн	29 221	29 423	25 484	-3 939	-13.4
БОЛОВСРОЛ						
Суралцагчид бүгд	хүүхэд	14 207	14 470	14 761	291	2.0
үүнээс 1-р ангид суралцагчид	хүүхэд	1 429	1 422	1 484	62	4.4
Төгсөгчид	хүүхэд	2 942	3 171	3 279	108	3.4
ЭРҮҮЛ МЭНД						
Амьд төрсөн хүүхэд	хүн	1 213	955	814	-141	-14.8
Амаржсан эх	хүн	1 209	949	815	- 134	-14.1
Халдварт өвчнөөр өвчлөгчид	хүн	924	617	865	248	40.2
СОЁЛ УРЛАГ						
Театрын тоглолт	тоо	41	57	80	23	40.4
Музейн үзэгчид	хүн	12 778	8 618	6 257	-2 361	-27.4
Номын сангийн уншигчид	хүн	37 708	14 769	13 495	-1 274	-8.6
ГЭМТ ХЭРЭГ						
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	456	497	692	195	39.2
Хэрэгт холбогсод	хүн	328	343	460	117	34.1
МӨНГӨ, БАНК						
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	145.2	175.5	182.1	6.6	3.8
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	232.1	307.9	340.4	32.5	10.6
АРИЛЖААНЫ ДААТГАЛ						
Арилжааны даатгалын орлого	сая.төг	1 311.7	1 456.3	1 569.4	113.1	7.8
Арилжааны даатгалын нөхөн төлбөр	сая.төг	326.9	824.0	272.4	- 551.6	-66.9
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ						
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	82.8	103.3	110.0	6.7	6.5
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	64.5	83.8	91.4	7.6	9.1
ҮНЭ						
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	7.1	7.6	5.9	-1.7	-22.4

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Жил			Өөрчлөлт	
		2023	2024	2025	Дүн	Хувь
МАЛ АЖ АХУЙ						
Малтай өрх	өрх	11 436	11 245	11 312	67	0.6
Малчин өрх	өрх	8 971	8 966	8 968	2	0.0
Малчдын тоо, бүгд	хүн	15 642	15 818	15 684	- 134	-0.8
Малын тоо, бүгд	мян.тол	3 859.5	2 008.9	2 309.5	300.6	15.0
Хувийн малын тоо, бүгд	мян.тол	3840.4	1 994.5	2 290.0	295.5	14.8
Хээлтэгч, бүгд	мян.тол	1 859.6	1 030.8	1 060.4	29.6	2.9
Том малын зүй бус хорогдол, бүгд	мян.тол	587.4	1 824.9	3.5	-1 821.4	-99.8
Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал	тол	300.0	83.0	54.0	-29.0	-34.9
ГАЗАР ТАРИАЛАН						
Тариалсан талбай						
Үүнээс: Үр тариа	га	4 150.0	3 868.0	5 210.0	1 342.0	34.7
Төмс	га	91.2	64.7	60.7	-4.0	-6.2
Хүнсний ногоо	га	68.2	48.7	47.2	-1.5	-3.1
Хураасан ургац						
Үүнээс: Үр тариа	т	2 865.0	2 395.0	2 833.0	438.0	18.3
Төмс	т	612.7	531.9	433.3	-98.6	-18.5
Хүнсний ногоо	т	1 060.6	569.2	570.1	0.9	0.2
АЖ ҮЙЛДВЭР						
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	221.3	301.4	472.9	171.5	56.9
Борлуулсан бүтээгдэхүүн *	тэрбум төгрөг	432.1	447.7	566.3	118.6	26.5
ТЭЭВЭР						
Тээврийн орлого	тэрбум төгрөг	14.2	14.1	15.0	0.9	6.7
Тээсэн ачаа	мян.т	250.6	201.7	250.4	48.7	24.1
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	15.6	17.6	22.6	5.0	28.4

Тайлбар: ** дахин

ХҮН АМ

2025 оны эцэст урьдчилсан дүнгээр 19.7 мянган өрх, 66.5 мянган суурин хүн амтай болж өмнөх оны мөн үеэс 12 өрхөөр, хүн ам 326 хүнээр тус тус өслөө.

Нийт өрхийн 9.9 мянга (50.1%), хүн амын 34.8 мянга (52.3%) нь аймаг, сумын төвд амьдарч байна.

Хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт хүн амыг насны ангиллаар авч үзвэл 0-14 насны хүн ам 21.3 мянга (31.9%), 15-34 насны хүн ам 18.3 мянга (27.6%), 35-59 насны хүн ам 20.9 мянга (31.4%), 60 ба дээш насны хүн ам 6.1 мянга (9.1%) болж, хүн ам зүйн ачаалал 60.0 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд хамгийн их өрх, хүн амтай Баруун-Урт сумын 1-р баг 1207 өрх, 4321 хүнээр 67 баг дотор тэргүүлж байгаа бол хамгийн бага өрх, хүн амтай нь Уулбаян сумын 4-р баг 85 өрх, 200 хүнтэй байна.

ЗУРАГ 1. СУУРИН ХҮН АМ, ӨРХИЙН ТОО, жил бүрийн эцсийн байдлаар



ЗУРАГ 2. ХҮН АМЫН НАС, ХҮЙСНИЙ СУВАРГА



ЗУРАГ 3. ХҮН АМЫН ТОО, насны бүлгээр



Улсын бүртгэлийн хэлтэст урьдчилсан байдлаар энэ онд шинээр төрсөн хүүхэд 905, нас барсан хүн 368, гэрлэлт 136, цуцлалт 40 тус тус бүртгүүлжээ. Сүхбаатар аймагт нийслэл, өөр аймгуудаас 765 иргэн шилжин ирж, 928 иргэн Сүхбаатар аймгаас өөр аймгууд руу шилжин явсан байна.

Аймгийн хэмжээнд 2025 онд бүтэн өнчин хүүхэд 35 болж өмнөх оноос 4 (12.9%)-өөр, эцэг, эхийн аль нэгэнтэй амьдарч буй 1268 болж өмнөх оноос 11 (0.9%)-ээр тус тус өссөн байна.

2025 оны эцэст 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх 651 болж, өмнөх оноос 5 (0.8%)-аар буурсан, 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг 101 болж, өмнөх оноос 2 (2.0%)-оор өссөн байна.

18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх (эцэг)-үүдийн 430 (57.2%) нь 3 хүртэлх, 280 (37.2%) нь 3-5, 42 (5.6%) нь 6, түүнээс дээш гишүүнтэй өрхийг толгойлж байгаа бөгөөд сумын төв болон хөдөөд 475 (63.2%) нь амьдарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 2025 оны жилийн эцэст 3.0 мянга болж, өмнөх оноос 15 (0.5%)-аар өсжээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1.0 мянга (33.2%) нь төрөлхийн, 2.0 мянга (66.8%) нь олдмол, төрлөөр авч үзвэл 413 (13.9%) нь хараа, 525 (17.6%) нь хөдөлгөөн, 102 (3.4%) нь хавсарсан, 87 (2.9%) нь яриа, 586 (19.7%) нь сэтгэц, 227 (7.6%) нь сонсгол, 1039 (34.9%) нь бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй байна.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 онд 815 эх амаржиж, 814 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оноос амаржсан эх 134 (14.1%)-өөр, амьд төрсөн хүүхдийн тоо 141 (14.8%)-ээр тус тус буурсан байна.

ЗУРАГ 4. ТӨРӨЛТ, жил бүрийн эцсийн байдлаар



1000 хүнд ногдох төрөлт өмнөх оны мөн үеэс 2.2 нэгж хувиар буурсан байна.

ЗУРАГ 5. НАС БАРАЛТ, жил бүрийн эцсийн байдлаар



2025 онд нас баралт 316 болж, өмнөх оноос 20 (6.0%)-оор буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 12.2, нас баралт 4.7, ердийн цэвэр өсөлт 7.5 байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн ам: Сүхбаатар аймгийн хүн амын өсөлт, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг тусгав.
Сүхбаатар аймагт оршин суугаа хүн ам гэж аймгийн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг ойлгоно.

Өрх: гэж нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.
Аймаг, сумын төвийн хүн амд Баруун-Урт сум болон сумын төвд оршин суугаа хүн амыг хамруулна. Хөдөөгийн хүн амд сумын төв, хөдөө амьдарч байгаа хүн амыг хамруулна.

Нийгмийн зарим үзүүлэлт:

БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД "Бүтэн өнчин хүүхэд" гэж Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасны дагуу эцэг, эх нь тогтоогдоогүй, эсвэл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг ойлгоно.

ЭЦЭГ, ЭХИЙН АЛЬ НЭГЭНТЭЙ АМЬДАРЧ БАЙГАА ХҮҮХЭД гэж эцэг эсвэл эх нь тогтоогдоогүй, эцэг эхийн аль нэг нь нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг эсвэл эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэр бүл салсны улмаас эцэг эсвэл эхийн асрамжид орсон 18 хүртэлх насны хүүхдийг ойлгоно.

18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХ /ЭЦЭГ/ Монгол Улсын "Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 Өрх толгойлсон эх /эцэг/ гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсвэл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эх /эцэг/ байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг хамааруулна". Өрх тэргүүлдэг гэсэн нөхцөл хангагдсан 18 хүртэлх насны хүүхэдтэй хүнийг насны хязгаар харгалзахгүйгээр өрх толгойлсон эх /эцэг/ -ийг ойлгоно.

Ганц биеэрээ өрх үүсгэн амьдарч буй ахмад настан Энэ үзүүлэлтээр өрх толгойлон ганц биеэрээ амьдарч буй ахмадын тоог гаргах бөгөөд үүнд өрх үүсгэн ганц биеэр амьдарч буй 55, түүнээс дээш насны эмэгтэй, 60, түүнээс дээш насны эрэгтэйг хамруулна.

Хүн амын ердийн цэвэр өсөлт: нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Хүн ам, өрхийн мэдээллийн сан, Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 18.4 хувиар өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2025 оны 12 дугаар сарын эцэст 277 болсны 124 (44.8%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 43 (18.4%) хүнээр өссөн байна.

2025 оны байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1631 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 833 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 6. **ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн байдлаар**



Ажилгүй иргэдийн 190 (68.6%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 2 (0.7%) нь магистр, доктор, 43 (15.4%) нь бакалавр, 8 (2.9%) нь тусгай мэргэжлийн дунд, 17 (6.3%) нь мэргэжлийн анхан шат, 124 (44.5%) нь бүрэн дунд, 55 (19.9%) нь суурь, 24 (8.8%) нь бага, 4 (1.5%) боловсролгүй хүмүүс байна.

ЗУРАГ 7. **БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшнээр, 2025 оны 12 дугаар сарын эцэст**

Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 11.5 (14.0%) тэрбум төгрөгөөр өслөө.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 2.3 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх оны мөн үеэс 0.4 (21.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 11.9 мянган иргэнд 93.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос 9.0 мянган өндөр настанд 73.9 тэрбум төгрөг, 1.3 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 9.8 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 2.7 тэрбум төгрөг, 0.4 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 6.9 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 21 иргэнд 0.3 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна.

Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 326 (12.6%) хүнээр, нийт тэтгэвэр олголт 11.5 (14.0%) тэрбум төгрөгөөр өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2025 онд нийгмийн халамжийн тэтгэвэрт 1.6 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2 (0.1%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 7.0 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.7 (11.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2025 онд 3.2 мянган хүн хамрагдсаны 50.2 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.8 хувь нь онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна.

2025 онд нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 18.7 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 2.3 (13.8%) тэрбум төгрөгөөр өсөж, 25.5 мянган хүн нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан нь
өмнөх оны мөн үеэс 3.9 (13.4%) мянган хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр

Үзүүлэлт	2023		2024		2025		Өөрчлөлт	
							Дүн	Хувь
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг		
Бүгд	**29 221**	**13 019.8**	**29 423**	**16 461.7**	**25 484**	**18 726.1**	**2 264.4**	**13.8**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	5 310	8 668.4	5 661	12 058.4	6 004	13 672.9	1 614.4	13.4
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 528	5 025.4	1 578	6 233.2	1 580	6 954.0	720.8	11.6
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 641	3 445.2	3 063	5 650.8	3 240	6 482.6	831.8	14.7
Нийгмийн халамжийн үйлчилгээ	179	88.7	332	80.2	507	143.4	63.3	78.9
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	962	109.1	688	94.3	677	92.9	- 1.4	- 1.5
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 800	748.0	5 967	759.9	6 237	1 564.8	804.9	2.1 [1]
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	7 600	538.8	7 360	591.3	3 474	582.3	- 9.0	- 1.5
Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	37	6.6	32	5.4	42	8.6	3.2	59.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	1 152	220.9	1 261	287.7	1 113	243.8	- 43.9	- 15.3
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	6 068	2 337.2	5 451	2 221.9	4 719	2 080.7	- 141.2	- 6.4
Насны хишиг	3 254	500.0	3 691	537.0	3 895	573.0	36.0	6.7

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 677 хүн хамрагдсан нь өмнөх оноос 11 (1.6%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журам өөрчлөгдсөнтэй холбоотой.

Халамжаас хөдөлмөрт гэсэн бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд Асгат, Наран, Сүхбаатар, Халзан, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян сумд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдахаа байсан.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын газрын нийгмийн даатгалын орлого, зарлагын улирлын мэдээ, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын сарын мэдээ

БОЛОВСРОЛ

2025-2026 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тоо өмнөх оноос 291-ээр өслөө.

Ерөнхий боловсролын сургууль: 2025-2026 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 14.8 мянган суралцагчид байгаагийн 7.4 (50.0%) мчнга нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 291 (2.0%) хүүхдээр өсчээ.
Нийт суралцагчдын 7.1 (47.9%) мянга нь 1-5-р ангид, 5.3 (35.9%) мянга нь 6-9-р ангид, 2.4 (16.1%) мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.5 мянган суралцагчид элсэн орсны 0.7 (49.8%) мянган эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 62 (4.4%) суралцагчаар өссөн байна. Мөн 12-р ангид 725 суралцагчид байгаагийн 408 (56.2%) нь эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 64 (9.7%) суралцагчаар өссөн байна.

Энэ хичээлийн жилд 488 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 30 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 21 байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 (-4.6%) хүүхдээр буурсан байна.

Ерөнхий боловсролын сургуульд нийт ажиллагсад 1.2 мянга байгаагийн 0.7 (54.2%) мянга нь үндсэн багш байна. Үүний 0.6 (85.3%) мянга нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 19 (2.8%) багшаар өссөн байна.

Дотуур байранд 1062 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 14 (1.3%) сурагчаар өссөн байна.

ЗУРАГ 8. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТОО



2024-2025 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийг 3.3 мянган сурагч төгсжээ.

Ерөнхий боловсролын сургуулийг 2024-2025 оны хичээлийн жилд нийт 3279 суралцагчид төгссөний 3259 сурагчид өдрөөр, дүйцсэнгээр 20 суралцагчид төгсжээ. Үүнээс: Өдрөөр бага боловсролыг 1421 (43.3%), суурь боловсролыг 1173 (35.8%), бүрэн дунд боловсролыг 665 (20.3%), дүйцсэнгээр бага боловсролыг 3 (0.09%), суурь боловсролыг 18 (0.5%) сурагчид тус тус төгсжээ. Өнгөрсөн оны

мөн үеэс нийт төгсөгчдийн тоо 108 (3.4%) суралцагчдаар өссөн байна. Нийт төгсөгчдийн 1687 (51.4%) эмэгтэй сурагчид байна.

ЗУРАГ 9. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ ТӨГСӨГЧИД



2025-2026 оны хичээлийн жилд Сургуулийн өмнөх боловсролд суралцагчдын тоо өмнөх оноос 123-аар буурсан байна.

Сургуулийн өмнөх боловсрол: 2025-2026 оны хичээлийн жилд 163 бүлэгт 5.4 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 2.6 (48.9%) мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 123 (-2.3%) хүүхдээр буурчээ.

2025-2026 оны хичээлийн жилд СӨБ-д 681 ажиллагсад байгаагийн 192 (28.1%) нь үндсэн багш, 151 (22.2%) нь туслах багш байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үндсэн багшийн тоо, туслах багшийн тоо ижил түвшинд байна.

ЗУРАГ 10. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО



2025-2026 оны хичээлийн жилд Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн сургуулийн суралцагчдын тоо өмнөх оноос 68-аар өслөө.

Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2025-2026 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 15 мэргэжлээр 473 суралцагчид суралцаж байгаагийн 166 (35.0%) нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 1 (0.2%) суралцагчаар өссөн байна.

Нийт суралцагчдын 125 (26.4%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 1 жилийн хугацаатай суралцаж байна.

Нийт суралцагчдын 77 (16.3%) барилга бүтэц, угсралт, 35 (7.4%) цахилгаан хангамж. тоног төхөөрөмж ашиглалт, 41 (8.7%) механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ, 57 (12.0%) хоолны үйлчилгээ, 28 (5.9%) үс засал, гоо сайхны үйлчилгээ, 33 (7.0%) оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 41 (8.7%) гагнуурчин, 30 (6.3%) электрон тоног төхөөрөмж ашиглалт, засвар үйлчилгээ гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Төгсөлт: Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг 2024-2025 оны хичээлийн жилд 7 мэргэжлээр 229 хүүхэд төгссөний 78 (34.1%) эмэгтэй хүүхэд байна. Нийт төгсөгчдөөс 1 жилийн хугацаатай 129 (56.3%) суралцагч мэргэжил эзэмшжээ. Өмнөх оны мөн үеэс төгсөгчдийн тоо 6 (2.0%) суралцагчаар нэмэгдсэн байна.

Нийт төгсөгчдийг мэргэжлийн төрлөөр нь авч үзвэл барилгын засал чимэглэгч мэргэжлээр 40 (17.5%), барилгын сантехник, хоолой угсралт мэргэжлээр 20 (8.7%), гар урлалын мэргэжлээр 17 (7.4%), мужаан, засвар үйлчилгээ 23 (10.0%), цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт 20 (8.7%), оёдолчин 20 (8.7%), фермерийн аж ахуй эрхлэлт 20 (8.7%), төмөр зам, замчин 20 (8.7%) ойжуулагч 14 (6.1%), үс засал, гоо сайхны үйлчилгээ 22 (9.6%), гагнуурчин 13 (5.7%), зэрэг мэргэжлээр тус тус төгссөн байна.

ЗУРАГ 11. **ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД**



Эх үүсвэр: Боловсролын газрын мэдээ.

ЭРҮҮЛ МЭНД

2025 онд эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2025 онд 815 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 134 (14.1%) эхээр буурсан байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 718 (88.2%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амласан, 32 (3.9%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, жил бүрийн байдлаар

Үзүүлэлт	2023	2024	2025	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Амаржсан эх	1 209	949	815	- 134	-14.1
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	1 173	892	744	- 148	-16.6
Гэрийн төрөлт	4	2	3	1	50.0
Амьд төрсөн хүүхэд	1 213	955	814	- 141	-14.8
1 цагийн дотор хөхөө амласан хүүхэд	1 155	879	718	- 161	-18.3
Төрөлхийн гажигтай төрсөн	8	9	4	- 5	-55.6
2500 граммаас доош жинтэй төрсөн	37	28	32	4	14.3
Амьгүй төрсөн хүүхэд	4	2	5	3	2.5 [1]
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	3.3	2.1	6.1	4.0	2.9 [1]

2025 онд нас баралтын 316 тохиолдол бүртгэгдсэний 26 (8.2%) нь осол гэмтлийн улмаас, 109 (34.5%) нь хорт хавдрын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн байдлаар

Үзүүлэлт	2023	2024	2025	Өөрчлөлт	
	Тоо			Дүн	Хувь
Нас баралт	298	336	316	-20	-6.0
Эмнэлгийн нас баралт	50	70	52	-18	-25.7
Эхийн эндэгдэл	1	1	-	-1	-
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	53	44	26	-18	-40.9
Хорт хавдрын өвчлөл нас баралт	79	107	109	2	1.9
0-1 насны эндэгдэл	6	7	8	1	14.3
1-5 хүртэлх насны эндэгдэл	5	3	1	-2	-66.7

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2025 онд 865 болж, өмнөх оны мөн үеэс 248 (40.2%)-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн байдлаар

Халдварт өвчин	2023	2024	2025	Өөрчлөлт	
	Хүн			Дүн	Хувь
Бүгд	**924**	**617**	**865**	**248**	**40.2**
Вируст гепатит	4	2	1	- 1	-50.0
Цусан суулга	32	14	16	2	14.3
Гахайн хавдар	2	1	-	- 1	-
Бруцеллёз	-	1	-	- 1	-
Салхинцэцэг	222	151	369	218	2.4 [1]
Энтервируст халдвар	149	83	5	- 78	-94.0
Улаан эсэргэнэ	14	-	2	2	-
Ecoli-оор/ A04.4/	-	14	2	- 12	-85.7
Ёлом	1	-	3	3	-
Салмонеллт	30	27	18	- 9	-33.3
Гар хөл амны өвчин	126	102	49	- 53	-52.0
Нярайн бактерт үржил	-	1	-	- 1	-
Хачигт	4	1	-	- 1	-
Халдварт эритема /B08.3/	-	-	36	36	-
Сүрьеэ	55	54	47	- 7	-13.0
Тэмбүү	34	47	73	26	55.3
Заг	49	78	80	2	2.6
Трихомониаз	59	41	31	- 10	-24.4
Ковид-19	143	-	-	-	-
Улаанбурхан	-	-	132	132	-
Менингококкт	-	-	1	1	-

Халдварт өвчний тохиолдлуудаас салхинцэцгээр 218 (2.4 дахин)-аар, заг хүйтнээр өвчлөгчид 2 (2.6%)-оор, тэмбүү 26 (55.3%)-аар нэмэгдсэн нь өндөр өсөлттэй байна.

Шинээр халдварт улаан бурхан өвчний 132, халдварт эритема 36, менингококкт 1 тохиолдол бүртгэгджээ.

Аймгийн хэмжээнд 2025 онд 283.4 мянган хүнд үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 2.4 (0.8%) мянган хүнээр өсөж, 15.1 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 74.9 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 13.4 (21.8%) мянган хүнээр өсжээ.

Түргэн тусламжийн дуудлага 15.5 мянган удаа гарсны 2.1 (13.2%) мянга нь алсын дуудлага байгаа нь өмнөх оны мөн үеэс 950 (31.6%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.
1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар

СОЁЛ, УРЛАГ

Хөгжимт жүжгийн театр 2025 онд 21.0 мянган үзэгчдэд 80 удаа тоглолтоор үйлчилсэн байна.

Өмнөх оны мөн үеэс тоглолтын тоо 23 (40.4%)-аар, танхимын үзэгчдийн тоо 7.3 (53.5%) мянгаар тус тус өссөн байна.

ЗУРАГ 12. НИЙТ ТОГЛОЛТЫН ТОО



ЗУРАГ 13. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



Угсаатны зүйн музей 2025 онд 6.3 мянган хүнд 2.8 мянган үзмэрээр үйлчилж, 2.6 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзмэрийн тоо 262 (10.3%)-оор, нийт үзвэр үзэгчдийн тоо 2.4 (19.3%) мянгаар, орлого өмнөх оны мөн үеэс 0.4 (13.3%) сая төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 14. НИЙТ ҮЗМЭРИЙН ТОО



ЗУРАГ 15. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



2025 онд 50.8 мянган номноос 15.7 мянган номоор, 13.5 мянган уншигчид номын сангаар үйлчлүүлжээ.

Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.4 (0.7%) мянгаар өсөж, уншигчдын тоо 1.3 (8.6%) мянган хүнээр буурсан байна.

ЗУРАГ 16. НИЙТ НОМЫН ТОО, мян ширхэг



ЗУРАГ 17. НИЙТ УНШИГЧДЫН ТОО, мян.хүн



Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Жаахан шарга хөгжимт жүжгийн театр, Усгаатны зүйн музей, Нийтийн номын сангийн улирлын мэдээ.

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 39.2%-иар өссөн байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар 692 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 20 хүн нас барж, 156 хүн гэмтэж бэртсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 2727.8 сая төгрөгийн хохирол учирсны 52.7 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 460 хүн холбогдон сэжиглэгдсэний 241 (47.6%) хүн нь согтуугаар, 19 (4.1%) хүн нь бүлгээр гэмт хэрэг үйлджээ.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 51 хүн эрүүлжүүлэгдсэн байна. Шүүхийн шийдвэрээр 333 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 692 гэмт хэргээс, илрүүлэлт 60.0 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.0 нэгжээр өссөн байна.

ЗУРАГ 18. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ ЗЭЭЛ

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл 2025 оны оны 12 дугаар сарын эцэст 3.1 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.9 хувийг эзэлж байна.

2025 оны 12 дугаар сарын эцэст Сүхбаатар аймаг дахь Монгол банкны салбарын мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 340.4 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 14.0 (4.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 32.5 (10.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 182.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 10.1 (5.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 6.6 (3.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийт хадгаламжийн 83.9 хувь нь хугацаатай, 16.1 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

ЗУРАГ 19. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг

Ойлголт, тодорхойлолт:

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

АРИЛЖААНЫ ДААТГАЛ

Даатгалын хураамжийн орлого өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өсжээ.

Даатгалын хураамжийн орлого 2025 онд 1.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 113.1 (7.8%) сая төгрөгөөр өсөж, даатгалын нөхөн төлбөрт 272.4 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 551.6 (66.9%) сая төгрөгөөр буурсан байна.

Даатгалын хураамжийн 73.1 хувийг сайн дурын даатгал, 26.9 хувийг албан журмын даатгал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	2023	2024	2025	Өөрчлөлт	
				Дүн	хувь
	сая төгрөг				
Хураамжийн орлого	1 311.7	1 456.3	1 569.4	113.1	7.8
Нөхөн төлбөр	326.9	824.0	272.4	-551.6	-66.9
Даатгуулагчдын тоо	26 725	53 531	44 898	-8 633	-16.1

Даатгалын хураамжийн нийт орлогын 422.8 (26.9%)-ийг сая төгрөгийг жолоочийн хариуцлагын даатгал, 407.6 (26.0%)-ийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 114.5 (7.3%)-ийг гэнэтийн ослын даатгал, 211.9 (13.5%) зуучлалын орлого эзэлж байна.

Даатгалын нөхөн төлбөрийн 45.0 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 40.9 хувийг тээврийн хэрэгслийн даатгал, 1.6 хувийг гэнэтийн ослын даатгал, 1.5 хувийг хөдөлмөрийн чадвараа түр алдсаны даатгал, 9.9 хувийг хурдан морь унаач хүүхдийн даатгал тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Даатгалын нөхөн төлбөр: Гэрээний дагуу даатгалын тохиолдолд үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.

Даатгалын үйл ажиллагаа: Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажилаагаа юм.

Даатгалын хураамж: Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно.

Эх үүсвэр: Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны даатгалуудын улирлын мэдээлэл

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 6.5 хувиар өсжээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2025 онд 110.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.7 (6.5%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 91.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 7.6 (9.1%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 20. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төгрөг



Аймгийн нийт төсвийн 48.6 хувийг орон нутгийн төсвийн орлого, 8.5 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 7.6 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 17.8 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг, 14.5 хувийг урьд оны үлдэгдэл, 3.1 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн боловсруулсан аймгийн төсвийн мэдээ.

төсөл, хөтөлбөр

Аймгийн хэмжээнд малжуулах хөтөлбөрт 90 өрхийг 4.5 мянган толгой мал 720.0 сая төгрөгийн төслийг хэрэгжүүлжээ.

Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 49 иргэнд 485.0 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 22 иргэнд 200.0 сая төгрөг, мод тарих арга хэмжээнд 415 иргэнд 243.5 сая төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 45 иргэнд 48.8 сая төгрөг, залуучуудын гарааны бизнесийн санхүүгийн дэмжлэг 2 иргэнд 30.0 сая төгрөг, малжуулах төсөл хөтөлбөрийн хэмжээнд 90 өрхөд 720.0 сая төгрөгөөр 4.5 мянган толгой малыг тус тус олгоод байна.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж, үйлчилгээний газраас мэдээллийг авч нэгтгэн оруулдаг.

ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.6 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 12 дугаар сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үе болон өмнөх оны эцсээс 5.9 хувь, өмнөх сараас 0.6 хувиар өссөн байна.

ЗУРАГ 21. **ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар**



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үе болон өмнөх оны эцсээс 5.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 9.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 5.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 7.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувь, эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, тээврийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 4.5 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.1 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 65.0 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2025 оны 12 дугаар сард өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 0.6 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 6. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, 2025 оны 12 дугаар сард

Бараа үйлчилгээний бүлэг	2025 XII / 2023 XII	2025 XII / 2024 XII	2025 XII / 2025 XI
	хувь		
Ерөнхий индекс	**14.7**	**5.9**	**0.6**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	15.4	9.2	1.5
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	2.0	5.8	0.0
Хувцас, бөс бараа, гутал	38.4	7.6	0.7
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	7.5	0.7	0.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	12.2	2.4	0.6
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	8.2	3.1	0.2
Тээвэр	0.1	4.5	0.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	2.2	1.3	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	4.4	-0.2	0.2
Боловсролын үйлчилгээ	0.0	0.0	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	42.9	12.1	0.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	78.8	65.0	0.0
Бусад бараа, үйлчилгээ	14.0	9.2	0.1

ЗУРАГ 22. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2025 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 12.8 хувиар өсөхөд гахайн махны үнэ дунджаар 6.3 хувь, үхрийн мах 16.2 хувь, хонь, ямааны мах 21.3 хувь, адууны мах 15.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Хязаалан гунан үхрийн үнэ Уулбаян, Түмэнцогт сумдад хамгийн өндөр буюу 3.0 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2025 оны 12 дугаар сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.3 сая төгрөг болж, 160.0 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.3 сая төгрөг болж, 237.6 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 2.6 сая төгрөг болж, 765.9 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 328.5 мянган төгрөг болж, 79.3 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 229.2 мянган төгрөг болж, 67.5 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 7. **НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 12 дугаар сард**

Төрөл	2022 XII	2023 XII	2024 XII	2025 XII	Өөрчлөлт	
	мян.төг				Дүн	Хувь
Нас гүйцсэн ат	1 062.5	1 187.5	1 187.5	1 347.5	160.0	13.5
Соёолон үрээ	912.5	1 072.7	1 054.5	1 292.1	237.6	22.5
Хязаалан гуна	1 477.3	1 622.2	1 809.1	2 575.0	765.9	42.3
Эр хонь	183.8	196.9	249.2	328.5	79.3	31.8
Эр ямаа	133.8	138.5	161.7	229.2	67.5	41.7

Хязаалан гунан үхрийн үнэ 2025 оны 12 дугаар сард Түмэнцогт, Уулбаян сумдад хамгийн өндөр буюу 3.0 сая төгрөг, Баяндэлгэр суманд хамгийн бага буюу 1.8 сая төгрөг байна.

ЗУРАГ 23. **НАС ГҮЙЦСЭН ЭР ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2025 оны 12 дугаар сард, мянган төгрөгөөр**



Боодолтой өвсний үнэ 2025 оны 12 дугаар сард 7.8 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 (5.3%) мянган төгрөгөөр буурч, хивэгний үнэ 29.0 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 4.4 (17.9%) мянган төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 24. **ГАЗАР ТАРИАЛАНГИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 12 дугаар сард, төгрөгөөр**



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэг, ченжүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

БИЗНЕС РЕГИСТР

Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн тоо өмнөх оноос 5.3 хувиар өслөө.

Статистикийн бизнес регистр (СБР)-ийн санд 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1936 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдэж, өмнөх оноос 97 (5.3%)-аар нэмэгдсэн байна.

Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй байгаа 1936 хуулийн этгээдийн 950 (49.2%) нь үйл ажиллагаа явуулж, 986 (50.9%) нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

Үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн 404 (40.9%) нь үйл ажиллагаа эхлээгүй, 546 (55.4%) нь үйл ажиллагаа түр зогсоосон, 36 (3.7%) нь үйл ажиллагаа бүрэн зогссон байна.

ХҮСНЭГТ 8. **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар**

Он	Бүгд	үйл ажиллагаа явуулж байгаа	үйл ажиллагаа явуулаагүй	эхлээгүй	түр зогсоосон	бүрэн зогсоосон
	тоо					
2023	1 484	812	672	104	561	7
2024	1 839	899	940	287	627	26
2025*	1 936	950	986	404	546	36

ЗУРАГ 25. **ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, хариуцлагын хэлбэрээр, 2025 оны эцэст**



Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн 547 (57.6%) нь компани, 232 (24.4%) нь бусад (ТБ, ТББ, бусад), 100 (10.5%) нь хоршоо, 48 (5.1%) нь нөхөрлөл, 23 (2.4%) нь ТӨҮГ, ОНӨҮГ байна.

Үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийг эдийн засгийн салбарын ангиллаар нь авч үзвэл бөөний болон жижиглэн худалдаа гэр ахуйн барааны үйлчилгээнд 352 (37.1%), үйлчилгээний бусад үйл ажиллагаанд 95 (10.0%), хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуйн салбарт 80 (8.4%), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаанд 63 (6.6%), боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаанд 57 (6.0%), төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын үйл ажиллагаанд 54 (5.7%) байгаа нь бусад салбарын аж ахуйн нэгж, байгууллагаас олон байна.

Ойлголт, тодорхойлолт

Статистикийн бизнес регистр: Тодорхой бүтэцтэй, тогтмол шинэчлэгдэн статистикийн зорилгоор ашиглагддаг аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл юм.

Статистикийн бизнес регистрийн санд нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт үйл ажиллагаа явуулахаар бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн салбар нэгжүүдийн статистикийн мэдээллийг хамруулна.

Статистикийн бизнес регистрийн мэдээллийн санг аж ахуйн нэгж, байгууллагын 1998 оны анхны тооллогын дүнд үндэслэн байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагын 2006, 2011, 2016, 2021 оны тооллогын дүн, мэдээллийн бусад эх үүсвэрээс тогтмол шинэчлэн баяжуулж байна.

Тайлбар: Бизнес регистрийн улирлын мэдээ

МАЛ АЖ АХУЙ

2025 оны эцэст мал тооллогын дүнгээр, аймгийн хэмжээнд 11.3 мянган малтай өрх, 48 аж ахуйн нэгж, байгууллагад нийтдээ 2.3 сая толгой мал тоологджээ.

Нийт малтай өрхийн дотор мал бүхий 2.3 мянган өрх, малчин 9.0 мянган өрх, тавиул малтай 90 өрх байна. Мал аж ахуйн салбарт 15.7 мянган малчид ажиллаж байна.

2025 оны тооллогын дүнгээр 237 өрх мянгаас дээш мал тоолуулсан бөгөөд шинээр 14 өрх мянгаас дээш мал тоолуулжээ.

ЗУРАГ 26. МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, сумаар



Нийт малтай өрхийн 68.1 хувийг 200 хүртэлх, 21.6 хувийг 201-500 хүртэлх малтай өрх, 10.3 хувийг 501 дээш малтай өрх эзэлж байгаа нь 200 хүртэлх малтай өрх өмнөх оноос 457 (5.6%)-оор буурсан бол 201-500 хүртэлх малтай өрхийн тоо өмнөх оноос 299 (13.9%), 501 дээш малтай өрх 225 (23.9%)-аар тус тус өссөн байна.

ЗУРАГ 27. МАЛЧИН ӨРХИЙН ТОО, сумаар



Мал сүрэг урьд оноос 0.3 сая толгойгоор өсөж, 2.3 сая толгой мал хүрсний дотор адуу 335.5 мянга, үхэр 216.5 мянга, тэмээ 5.8 мянга, хонь 943.8 мянга, ямаа 807.8 мянга толгой болжээ.

ЗУРАГ 28. МАЛЫН ТОО, төрлөөр, 2025 онд



Нийт мал сүрэгт хонь 40.9 хувь, ямаа 35.0 хувь, адуу 14.5 хувь, үхэр 9.4 хувь, тэмээ 0.2 хувийг эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 382.4 мянган толгой малаараа Эрдэнэцагаан сум тэргүүлж байна.

Малын төрлөөр авч үзвэл адуу 60.4 мянган толгой, үхэр 34.6 мянган толгой, хонь 145.5 мянган толгой, ямаа 141.3 мянган толгой малаар Эрдэнэцагаан сум, 1.2 мянган толгой тэмээгээр Түвшинширээ сум аймагтаа тэргүүлж байна.

ЗУРАГ 29. МАЛЫН ТООГООР ТЭРГҮҮЛЖ БАЙГАА СУМ, мянган толгой

I	Эрдэнэцагаан	382.4	Эрдэнэцагаан	60.4	Эрдэнэцагаан	34.6	Түвшинширээ	1.2	Эрдэнэцагаан	145.5	Эрдэнэцагаан	141.3
II	Мөнххаан	296.2	Сүхбаатар	43.1	Баруун-Урт	26.6	Баяндэлгэр	0.7	Мөнххаан	132.3	Мөнххаан	104.0
III	Баяндэлгэр	224.4	Баруун-Урт	40.4	Мөнххаан	25.5	Сүхбаатар	0.7	Онгон	113.3	Баяндэлгэр	94.9
IV	Онгон	220.2	Мөнххаан	34.2	Дарьганга	17.7	Онгон	0.7	Баяндэлгэр	94.8	Түвшинширээ	72.6
V	Баруун-Урт	202.9	Дарьганга	30.2	Онгон	17.6	Эрдэнэцагаан	0.6	Сүхбаатар	81.4	Онгон	68.8

ЗУРАГ 30. МАЛЫН ТОО, сая толгой



2025 онд 1.1 сая хээлтэгч мал тоологдож өмнөх оноос 29.6 (2.9%) мянган толгой малаар өссөн байна.

ЗУРАГ 31. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, мянган толгой



2025 онд нийт 4.4 мянган толгой тэжээвэр амьтад тоолууллаа. Үүнээс 213 гахай, 4.1 мянган тахиа, зөгий 52 бүл, бусад 1 тоологдсон байна.

ЗУРАГ 32. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, толгой



Мал төллөлт 2025 оны эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 78.1 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар оны эхний төллөх насны 1.0 сая хээлтэгч малын 811.4 (78.7%) мянга нь төллөжээ. Гүүний 71.2 хувь, үнээний 73.1 хувь, ингэний 44.0 хувь, эм хонины 80.1 хувь, эм ямааны 80.8 хувь нь төллөсөн байна.

ХҮСНЭГТ 9. **МАЛ ТӨЛЛӨЛТ, төрлөөр**

Малын төрөл	Оны эхний хээлтэгч			Төллөсөн хээлтэгч			Төллөлтийн хувь		
	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025
	мянган толгой						хувь		
Дүн	**2 063.7**	**1 859.6**	**1 030.8**	**1 548.8**	**554.4**	**811.4**	**75.1**	**29.8**	**78.7**
Адуу	128.1	127.5	114.1	90.2	46.1	81.2	70.4	36.1	71.2
Үхэр	134.9	127.2	82.3	94.4	42.6	60.2	70.0	33.5	73.1
Тэмээ	3.1	3.0	2.5	1.3	0.9	1.1	43.1	28.6	44.0
Хонь	1 130.5	1 027.5	463.3	874.9	312.6	370.9	77.4	30.4	80.1
Ямаа	667.2	574.3	368.6	488.1	152.3	297.9	73.2	26.5	80.8

ЗУРАГ 33. **ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛЛӨЛТ, мянган толгой**



Бойжуулсан төл 2025 оны эцсийн байдлаар 812.3 мянга болж, бойжилтын хувь 99.8 хувь байна. Гарсан унаганы 99.9 хувь, тугалын 99.9 хувь, ботгоны 99.9 хувь, хурганы 99.8 хувь, ишигний 99.8 хувь нь бойжжээ.

Аймгийн хэмжээнд 1.6 мянган толгой төл мал хорогдсоныг төрлөөр нь авч үзвэл: унага 100, тугал 67, ботго 1, хурга 711, ишиг 687 толгой төл мал тус тус хорогдоод байна.

ХҮСНЭГТ 10. БОЙЖУУЛСАН ТӨЛ, төлийн төрлөөр, 2025 оны жилийн эцсийн байдлаар, мянган толгой

Төлийн төрөл	Гарсан төл			Бойжуулсан төл			Төл бойжилтын хувь		
	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025
Дүн	**1 552.0**	**554.8**	**813.9**	**1 102.9**	**446.8**	**812.3**	**71.2**	**80.5**	**99.8**
Унага	90.2	46.1	81.2	71.6	43.3	81.1	95.0	93.6	99.9
Тугал	94.4	42.6	60.2	78.3	40.1	60.2	79.4	94.0	99.9
Ботго	1.3	0.9	1.1	1.3	0.8	1.1	83.0	94.0	99.9
Хурга	876.5	312.9	372.0	624.1	246.9	371.3	71.3	78.9	99.8
Ямаа	489.6	152.4	299.3	327.7	115.7	298.6	67.1	75.9	99.8

